

ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2022оны 12-р сарын 31-ний өдрөөрх

/төгрөгөөр/			
ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2021	12/31/2022
А.ХӨРӨНГӨ			
1.Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1	2,288,056,163.17	38,938,093.74
Дансны авлага	2	2,064,564,311.52	4,085,829,768.55
Татвар, НДШ-ийн авлага		563,081.77	13,293,394.98
Бусадавлага			
Бусад санхүүгийн хөрөнгө	3	1,209,699,197.18	1,209,699,197.18
Бараа материал	4	102,978,542.00	99,585,928.37
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	5	158,875,000.00	4,718,250.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		5,824,736,295.64	5,452,064,632.82
2.Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	6	1,608,290,146.98	1,603,459,948.23
Хөрөнгө оруулалтын зориулалттай үлхөдлөх хөрөнгө	8	448,584,506.54	448,584,506.54
Бусад эргэлтийн бус хөрөнгө	7	1,056,527,071.91	1,056,527,071.91
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		3,113,401,725.43	3,108,571,526.68
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		8,938,138,021.07	8,560,636,159.50
Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
1.Өр төлбөр			
Дансны өглөг			-
Цалингийн өглөг	9	2,299,104.00	1,277,280.00
Татварын өр	9	2,154,209.01	-
Урьдчилж орсон рлого		-	-
Богино хугацааг төрөлбөрийн дүн		4,453,313.01	1,277,280.00
Өртөлбөрийн нийт дүн		4,453,313.01	1,277,280.00
2.Эздийн өмч			
а. Хувьцаат	10	13,750,000,000.00	13,750,000,000.00
Халаасныху хувьцаа	11	(4,497,462,000.00)	(4,497,462,000.00)
Нэмж төлөгдсөн капитал	12	3,144,262,800.00	3,144,262,800.00
Хуримтлагдсан ашиг, алдагдал	13	(3,463,116,091.94)	(3,837,441,920.50)
Эздийн өмчийн дүн		8,933,684,708.06	8,559,358,879.50
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		8,938,138,021.07	8,560,636,159.50

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
 2022оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2021	12/31/2022
Борлуулалтынорлого(цэвэр)	14	52,074,979.13	1,666,973.63
Борлуулалтынөртөг	16	18,170,926.18	-
Нийташиг /алдагдал/		33,904,052.95	1,666,973.63
Хүүгийнорлого	15	27,890,410.94	-
Ерөнхийбаудирдлагынзардал	16	538,039,619.93	406,964,846.63
Гадаадвалютынханшийнзөрүүнийолз (гарз)	15	(58,221.33)	30,972,044.44
Хөрөнгөоруулалтборлуулсанаасүүссэнолз (гарз)		(834,518,405.50)	-
Татвартөлөхийнөмнөхашиг (алдагдал)		(1,310,821,782.87)	(374,325,828.56)
Орлогынтатварынзардал	17	(46,559,891.09)	-
Татварындараахцэвэршиг (алдагдал)		(1,357,381,673.96)	(374,325,828.56)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	13	(1,357,381,673.96)	(374,325,828.56)
Бусад дэлгэрэнгүй орлого			
Орлогыннийтдүн		(1,357,381,673.96)	(374,325,828.56)
Нэгжхувьцаандногдохсуурьшиг (алдагдал)			

Хавсаргасантэмдэглэлүүдньэнэхүүсанхүүгийнтайлангийнсалшгүйхэсэгболно.

**ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2022оны 12-р сарын 31-ний өдрөөрх

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	12/31/2021	12/31/2022
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Мөнгөн орлогын дүн (+)		54,607,477.00	1,528,341.00
Барааборлуулсан, үйлчилгээзүүлсэн орлого		54,607,477.00	1,528,341.00
Мөнгөн зарлагын дүн (-)		(1,092,706,388.34)	(391,415,374.37)
Ажиллагчдад төлсөн		223,653,068.51	204,850,582.03
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		27,460,211.60	26,984,984.49
Бараа материал худалданавахад		2,241,106.30	1,600,146.35
Ашиглалтын зардалд төлсөн		1,251,128.60	2,766,310.07
Түлш шатахуун, тээврийн хөлстөлсөн		42,543,633.54	38,991,598.88
Хүүний төлбөрт төлсөн		-	-
Татварын байгууллагад төлсөн		425,981,323.66	6,072,838.39
Бусад мөнгөн зарлага		369,575,916.13	110,148,914.16
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(1,038,098,911.34)	(389,887,033.37)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)		3,509,234,000.94	
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		3,481,343,590.00	
Хүлээн авсан хүүний орлого	15	27,890,410.94	
Мөнгөн зарлагын дүн (-)		(562,984,000.00)	(1,890,203,080.50)
Бусад долгосон зээл, мөнгөн урьдчилгаа		562,984,000.00	1,890,203,080.50
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		2,946,250,000.94	(1,890,203,080.50)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)		-	30,972,044.44
Валютын хангийн тэгшитгэлийн ашиг		-	30,972,044.44
Мөнгөн зарлагын дүн (-)		(58,221.33)	
Зээл, өрийн нүт цаасны төлбөрт төлсөн		-	-
Хувьцаа буцаан худалдаж төлсөн		-	-
Валютын хангийн тэгшитгэлийн алдагдал		58,221.33	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		(58,221.33)	30,972,044.44
Бүхцэвэр мөнгөн гүйлгээ		1,908,092,868.27	(2,249,118,069.43)
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн нэхний үлдэгдэл</i>	<i>1</i>	<i>379,963,294.90</i>	<i>2,288,056,163.17</i>
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн нэцсийн үлдэгдэл</i>	<i>1</i>	<i>2,288,056,163.17</i>	<i>38,938,093.74</i>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

1. АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Сүлд-Аудит ХХК ба Фронттиер Лэнд Групп ХК-ийн хооронд 2023 оны 01 дүгээр сарын 31-нд хийсэн аудитын ажил гүйцэтгэх гэрээний дагуу бид танай компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний аудитын зорилго

Фронтинер Лэнд Групп ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ба Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бэлтгэгдсэн гэдгийг батлахад оршино. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу явуулсан бөгөөд аудитын ажлын баримтууддаа үндэслэн дүгнэлт гаргасан болно.

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТУХАЙ

Фронтинер Лэнд Групп ХК-ийн санхүүгийн тайлан нь Монгол улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлж гарган, Сангийн Сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар батлагдсан заавар журам маягтын дагуу бэлтгэгдсэн байна. Санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ түүхэн өртгийн, орлогод тооцоололтын, орлого зардал зохицох, тасралтгүй байх, нэмэлт тодруулгын гэсэн үндсэн зарчмуудыг баримталдаг билээ. Компани нягтлан бодох бүртгэлээ Диамонд 5.0 програм хангамжийг ашиглан аккрузель сууриар хөтөлдөг. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтүүдийг Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлсэн байна.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

• Санхүүгийн тайлан бэлтгэсэн байдал

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлангуудаас бүрдэж байна.

• Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Арилжааны цэвэр орлого”-д тусгана.

• Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийг багтаасан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь бүртгэнэ. “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Энэ ангилалд өрийн үнэт цаас, өөрийн хөрөнгө болон голдуу ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд багтана. Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр олз гарз” дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүгийн орлого, зардалд хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.

• Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт” гэж ангилсан эсвэл “Бодит үнийн өөрчлөлт нь орлого зарлагын дансанд бүртгэгдэх”, “Дуусгавар хугацаа хүртэл эзэмших”, “Зээл ба урьдчилгаа” гэсэн ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэглүүр, хөрөнгө оруулалтын байгууллагад хийсэн хөрөнгө оруулалтууд ба мөнгөний зах зээл ба бусад өрийн хэрэгслүүд багтдаг. Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Бодит бус ашиг алдагдлыг шууд өөрийн хөрөнгөд “Борлуулахад бэлэн сан”-д хүлээн зөвшөөрдөг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өмнө хүлээн зөвшөөрсөн

хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлогын дэл гэрэнгүй тайлангийн “Үйл ажиллагааны орлого” эсвэл “Бусад үйл ажиллагааны зардал”-д хүлээн зөвшөөрнө.

- **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**

Компани мөнгөн хөрөнгөө Касс дахь бэлэн мөнгө (төгрөг) ба Банкны харилцах данс (төгрөг) гэж ангилан бүртгэдэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг. Гадаад валютаар хийгдсэн гүйлгээг тухайн үеийн Монгол банкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэдэг. Гадаад валютын дансдын үлдэгдлийг тайлант жилийн эцэс дэх тухайн валютын хаалтын ханшаар тайлагнасан. Албан ханш ба гүйлгээний ханшны зөрүүг “*Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)*” дансанд бүртгэж орлого үр дүнгийн тайланд үйл ажиллагааны бус олз (гарз)-аар тайлагнадаг.

- **Авлага**

Авлагыг урьдчилан тооцоолсон боломжит үнэ цэнээр нь бүртгэлд тусгадаг. Найдваргүй авлагыг бүртгэх шууд данснаас хасах аргын дагуу авлагыг найдваргүй нь нотлогдсон үед найдваргүй авлагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх ба найдваргүй болсон авлагын дүнгээр дансны авлагыг бууруулна.

- **Барааматериал**

Худалдан авсан бараа материалын өртөг нь худалдан авсан үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой гарсан бэлтгэл ажиллагааны зардлаас бүрдэнэ. Бараа материалын бүртгэл хөтлөхдөө “байнгын систем” ашиглах ба энэ системийн үед бараа материалыг худалдан авсан өртгөөр нь бүртгэнэ.

- **Үндсэн хөрөнгө ба түүний элэгдэл**

Үндсэн хөрөнгийг анхны худалдан авалтын өртгөөр нь бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь түүнийг худалдаж авсан үнэ, олж бэлтгэхтэй холбоотой зардлууд болон ашиглалтын явцад капиталжих зардлаас бүрдэнэ. Үндсэн хөрөнгийг шулуун шугамын арга ашиглан, ашиглалтын хугацааных нь туршид элэгдүүлсэн. Хөрөнгийг бүрэн элэгдүүлж дуусах хугацааг дараах байдлаар харуулав.

Барилга байгууламжийг	10-60 жил
Машин тоног төхөөрөмжийг	5-15 жил
Тавилга эд хогшил, бусад хөрөнгийг	10 жил
Компьютер ба түүнтэй адилтгах хөрөнгийг	5 жил

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрч, зарж борлуулах данснаас хасах үед өмнө нь үүссэн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан ашигруу шилжүүлдэг.

- **Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэдэг байна. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг хөрөнгийн онцлог шинж чанарыг харгалзан тодорхойлох ба шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

- **Өр төлбөр**

Өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бусдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага бөгөөд ирээдүйд төлөх бодит өртгөөрөө бүртгэлд тусгагддаг. Өр төлбөрийг богино хугацаат болон

урт хугацаат өр төлбөр гэж ангилан балансанд тусгаж, богино хугацаат өр төлбөрийг дансны болон бусад өр төлбөр гэж бүртгэжээ. Богино хугацаат өр төлбөрийн дансанд дансны өглөг, татвар нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, цалингийн өглөг, бусад татварын өглөг, урьдчилж орсон орлого зэргийг бүртгэсэн байна.

- **Татвар тооцолт**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.1-д заасны дагуу аж ахуйн нэгж байгууллагууд 3 тэр бум хүртэл төгрөгийн татвар ногдуулах орлогод 10%-иар, 3 тэр бум төгрөгөөс дээш орлогод 25%-иар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар тооцож төлөх шатлалын дагуу татварын тооцоог хийж улсын төсөвт төлдөг байна.

Хувь хүний орлогын албан татвар Монгол улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасны дагуу ажилчдын цалингаас 10%-иар татвар суутган авч орон нутгийн төсөвт төлдөг.

Нийгмийн даатгал Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу ажиллагсад олгохоор тооцсон цалингаас 11.5%, байгууллага ажилчдад 12.5%-иар, нийт 24.0%-иар нийгмийн даатгалын шимтгэл төлдөг.

Нэмэгдсэн өртгийн албан татвар Монгол улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5.2-д заасны дагуу компанийн импортолсон буюу экспортолсон бараа эсвэл борлуулалтын орлого 50.0 сая төгрөгт хүрсэн өдөр нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлнэ. Нэмэгдсэн өртгийн албан татварыг борлуулалтын орлогын дүнгээс 10%-иар тооцдог. Борлуулалтын орлогоосоо НӨАТ төлөхөөс гадна худалдан авсан бараа үйлчилгээндээ төлсөн НӨАТатвараа төлөх татвараасаа суутган тооцдог. НӨАТ-ын тайлангаа сараар тайлагнаж татварын албатай тооцоогоо хийсэн байна.

- **Орлогыг хүлээн зөвшөөрөх**

Эдийн засгийн үр ашиг нь компанид орох магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон үед орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлого нь НӨАТ болон бусад татвар хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр бодит үнэ цэнээр хэмжигддэг. Үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны орлогыг аккруэль сууриар бүртгэдэг. Хүүгийн орлого хүү нь үр ашигт хүүгийн аргаар хуримтлагдаж бүртгэгдэнэ.

- **Хувь нийлүүлсэн хөрөнгө**

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаат капитал, дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан үр дүнгээс бүрддэг. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болон хуримтлагдсан үр дүнгийн дансууд нь санхүүгийн тайланд анхны буюу түүхэн ханшаар тайлагнагдсан байна.

- **Өртөг, Зардал**

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбогдон гарсан бүх зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд тусгадаг бөгөөд эдгээр зардлыг аккруэль сууриар бүртгэдэг байна .

ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП ХК-ИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ТОДРУУЛГА 1. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Фронттиер Лэнд Групп ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мөнгөн хөрөнгө дараах байдалтай байна.

Д/д	Үзүүлэлт	2021.12.31	/мян.төгрөг/ 2022.12.31
1	Кассан дахь бэлэн мөнгө MNT	22.8	-
	Бэлэн мөнгөний дүн	22.8	-
1	ХААН Банк 5038016921 MNT	95,796.2	37.0
2	ХААН Банк 5038016932 USD	152,141.9	1,370.5
3	Харилцахданс /495071430/	2,040,095.3	37,530.6
	Бэлэнбүсмөнгөнийдүн	2,288,033.4	37,938.1
	Нийтмөнгөнхөрөнгийндүн	2,288,056.2	38,938.1

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр эдгээр дансдын санхүүгийн бүртгэл дэхь үлдэгдэл нь байршиж буй банкуудаас авсан дансны гүйлгээ үлдэгдлийн баталгааны дүнтэй тохирч байна.

ТОДРУУЛГА 2. АВЛАГА

Үзүүлэлт	2021.12.31	/мян.төгрөг/ 2022.12.31
Дансны авлага	1,820.0	1,820.0
Ажилчдаас авах авлага	3,264.7	3,264.7
Хувь хүмүүсээс авах авлага	2,063,355.0	4,082,745.5
Бусад авлага	563.1	13,293.4
Байгууллага хоорондын авлага	176,636.4	178,511.4
Найдваргүй авлын нөөц	(179,948.7)	(179,948.7)
Авлагын дүн	2,065,690.5	4,099,123.1

Тайлант жилд тус компанийн авлага нь 2,033,432.6 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх онуудын авлагын үлдэгдлээс “Морьт Импэкс” ХХК-ийн төлөгдөөгүй он дамжсан авлага байна. 179,948.7 мянган төгрөгийн найдваргүй авлагын нөөцөд өөрчлөлт ороогүй байна. “Морьт Импэкс” ХХК-ийн дансны авлагаас бусад авлагууд нь төлөгдөх хугацаандаа байгаа авлагууд бөгөөд уг авлагуудад гадаад валютаар илэрхийлэгдсэн авлага байхгүй.

ТОДРУУЛГА 3. БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Үзүүлэлт	2021.12.31	/мян.төгрөг/ 2022.12.31
Гадаад хувьцаагаарх хөрөнгө оруулалт	53,015.2	53,015.2
Хөрөнгө оруулалт	1,156,684.0	1,156,684.0
Нийт дүн	1,209,699.2	1,209,699.2

Өмнөх онуудад “Вистекс глобал инвест” ХХК-ийн хөрөнгө оруулалтын гэрээний дагуу богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд 1,154,000.0 мянган төгрөг, Баянгол зочид буудал, Зоос банкны хувьцаа худалдан авсан 2,684.0 мянган төгрөгийг тус тус бүртгэсэн байна.

ТОДРУУЛГА 4. БАРАА МАТЕРИАЛ

Үзүүлэлт	2021.12.31	/мян.төгрөг/ 2022.12.31
Хангамжийн материал	94,663.5	94,663.5
Хангамжийн материал / бусад/	3,297.3	2,390.9

Хангамж материал / ашиглалтанд/	4,577.0	2,171.5
Хангамж материал /суудлын бүрээс/	360.0	360.0
Хангамж материал / ашиглалтанд/	80.7	-
Нийт дүн	102,978.5	99,585.9

Хангамжийн материал дансан дахь 94,663.5 мянган төгрөгийн хөрөнгө нь хайрга, ажлын хувцас зэрэг материал байгаа ба тухайн байгууллага нь олон жил болсон эргэлтийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоогүй байна. Бусад хангамжийн материал дансан дахь хөрөнгө нь байгууллагын дотоод хэрэгцээнд болон оффисын хэрэгцээний бичиг хэргийн материал мөн ажлын багаж хэрэгслийг бүртгэсэн байна.

ТОДРУУЛГА 5. УРЬДЧИЛЖ ГАРСАН ЗАРДАЛ

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Урьдчилж гарсан зардал	158,875.0	4,718.3
Нийт дүн	158,875.0	4,718.3

ТОДРУУЛГА 6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ-1

Үзүүлэлт	Барилга байгууламж	Машин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийтхөрөнгө
ӨРТӨГ							
2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	138,639.5	370,482.5	56,798.3	20,142.7	9,024.7	8,616.7	603,704.4
Нэмэгдсэн	-	-	-	-	-	-	-
Худалдаж авсан							
Хасагдсан							
Худалдсан							
Акталсан							
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	138,639.5	370,482.5	56,798.3	20,142.7	9,024.7	8,616.7	603,704.4
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ							
2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	27,901.7	370,482.5	56,798.3	20,090.3	9,024.7	8,616.7	503,248.8
Нэмэгдсэн	4,796.8			33.3	-		5,249.7
Байгуулсан элэгдэл	4,796.8			33.3			5,249.7
Хасагдсан	-	-					
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл	-						
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	32,698.5	370,482.5	56,798.3	20,123.7	9,024.7	8,616.7	492,914.4
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН							
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	105,940.9	(0.0)	-	18.9	-	-	105,959.8

ҮНДСЭН ХӨРӨНГӨ-2

Үзүүлэлт	2021.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
-----------------	-------------------	------------------	------------------	-------------------

Газрын сайжруулалт	1,497,500.0	1,497,500.0
НИЙТ ДҮН	1,497,500.0	1,497,500.0

Тайлант 2022 онд газрын сайжруулалт дансанд ямар нэгэн гүйлгээ гараагүй байна.

ТОДРУУЛГА 7-а. ДУУСААГҮЙ БАРИЛГА

Үзүүлэлт	2021.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
Дуусаагүй барилга	296,221.2			296,221.2
Төслийн судалгааны ажил	579,829.3			579,829.3
НИЙТ ДҮН	876,050.5			876,050.5

Тайлант 2021 онд дуусаагүй барилга дансанд ямар нэгэн гүйлгээ гараагүй байна.

ТОДРУУЛГА 7-б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2021.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
Хөрөнгө оруулалт	180,476.5			180,476.5
НИЙТ ДҮН	180,476.5			180,476.5

Тайлант 2022 онд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө дансанд ямар нэгэн гүйлгээ гараагүй байна.

ТОДРУУЛГА 8. БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2021.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	448,584.5		-	448,584.5
Нийт дүн	448,584.5		-	448,584.5

ТОДРУУЛГА 9. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Цалингийн өглөг	2,299.1	1,277.3
НӨАТ-ын өглөг	2,154.2	-
Өглөгийн дүн	4,453.3	1,277.3

Тайлант хугацаанд богино хугацаат өглөг 3,176.0 мянган төгрөөр буурсан. Дээрхи өглөг нь тайлант хугацаандаа төлөгдөж байгаа цалингийн өглөг байна.

ТОДРУУЛГА 10. ХУВЬЦААТ КАПИТАЛ

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Энгийн хувьцаа	13,750,000.0	13,750,000.0
Нийт дүн	13,750,000.0	13,750,000.0

Компанийн хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 13,750.0 мянган ширхэг энгийн хувьцаа байна

Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн талаар:

2022/12/31-ний байдлаар

№	Брокер дилерийн компани нэр	Тоо ширхэг	Хувьцаа эзэмшигчдийн тоо
1	Масдак ҮЦК ХХК	374	4
2	Зэргэд ҮЦК ХХК	794	3
3	Би ди сек ҮЦК ХК	1,366,112	111
4	Өндөрхаан инвест ҮЦК ХХК	3,381	8
5	Алтан хоромсог ҮЦК ХХК	220	2
6	Мэргэн санаа ҮЦК ХХК	1000	1
7	Булган брокер ҮЦК ХХК	10	1
8	Монсек ҮЦК ХХК	14595	4
9	Санхүүгийн хөгжил инвест	1	1
10	ТТсек	10	1
11	Өлзий энд ко капитал ҮЦК ХХК	29,181	8
12	Мандал капитал маркетс ҮЦК ХХК	14,417	7
13	Блюскай секьюритиз ҮЦК ХХК	630	1
14	Таван богд капитал ҮЦК ХХК	400	1
15	Апекс капитал ҮЦК ХХК	200	1
16	Монгол секьюритиз ҮЦК ХХК	86	1
17	Тулгат чандмань баян ҮЦК ХХК	341	3
18	Бумбат-алтай ҮЦК ХХК	261	3
19	Азиа пасифик секьюритис	6,716	4
20	Аргай бэст ҮЦК ХХК	1422	4
21	Дэлгэрхангай секьюритиз	630	4
22	Ард секьюритиз ҮЦК ХХК	72,547	5
23	АСЕ энд Т капитал ҮЦК ХХК	5,001	2
24	Фронитер ҮЦК ХХК	595	2
25	Блумсбюри секьюритис ҮЦК ХХК	3,281	4
26	Ди си эф ҮЦК ХХК	7,920	2
27	Эм ай си си ҮЦК ХХК	12,479	3
28	Тэнгэр капитал ҮЦК ХХК	1	1
29	Гаули ҮЦК ХХК	15,820	1
30	Лайф тайм инвестмент ҮЦК ХХК	1	1
31	Евразиа капитал холдинг	11,968,931	18
32	Гүүд сек ҮЦК ХХК	80	1
33	Эм даблью Ти Эс ҮЦК ХХК	10	1
34	Ти Ди Би Капитал ҮЦК ХХК	9,679	11
35	Новел инвестмент	700	1
36	Стандарт инвестмент ҮЦК ХХК	199,097	16
37	Гацуурт трейд	412	3
38	Голомт капитал ҮЦК ХХК	12,665	3
Нийт хувьцааны дүн		13,750,000	248

ТОДРУУЛГА 11. ХАЛААСНЫ ХУВЬЦАА

	/мян.төгрөг/	
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Халаасны хувьцаа	(1,353,199.2)	(1,353,199.2)
Нийт дүн	(1,353,199.2)	(1,353,199.2)

ТОДРУУЛГА 12. НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

/мян.төгрөг/

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Хувьцааны үнийн зөрүү	(3,144,262.8)	(3,144,262.8)
Нийт дүн	(3,144,262.8)	(3,144,262.8)

ТОДРУУЛГА 13. ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ), НОГДОЛ АШИГ

/мян.төгрөг/				
Эхнийүлд эгдэл	Бүртгэлийнбодлогы нөөрчлөлт	Өмчид гарсан өөрчлөлт	Тайлантүеийнцэвэр аш игалдагдал	Эцсийнүлд эгдэл
(3,463,116. 1)			(374,325.8)	(3,837,441.9)

ТОДРУУЛГА 14. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

/мян.төгрөг/		
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Борлуулалтын орлого	52,074.9	1,666.9
Нийт орлогын дүн	52,074.9	1,666.9

Тайлант хугацааны 1,666.9 мянган төгрөг нь өмнөх оны тооцоо байна.

ТОДРУУЛГА 15. БУСАД ОРЛОГО

/мян.төгрөг/		
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Гадаад валютын бодит бус ашиг	(58,221.3)	(30,972.0)
Нийт ашиг алдагдлын дүн	(58,221.3)	(30,972.0)

ТОДРУУЛГА 16. ӨРТӨГ БА ЗАРДАЛ

/мян.төгрөг/			
Данснынэр	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
Цалингийн зардал	241,756.8	206,025.5	(35,731.3)
НДШ-ийн зардал	27,460.2	25,675.4	(1,784.8)
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	647.3	768.2	120.9
Бичиг хэргийн зардал	455.6	831.9	376.3
Шуудан холбооны зардал	5,244.4	8,198.5	2,954.1
Сургалтын зардал	525.0	500.0	(25.0)
Ашиглалтын зардал	251.3	3,124.7	2,873.4
Элэгдлийн зардал	5,249.7	4,830.2	(419.5)
Түрээсийн зардал	20,743.2	83,626.4	62,883.2
Албан томилолтын зардал	13,999.4	11,613.6	(2,385.8)
Харуул хамгаалалтын зардал	36,062.0	34,122.3	(1,939.7)
Мэргэжлийн үйлчилгээний зардал	75,394.8	10,056.0	(65,338.8)
Шатахууны зардал	1,236.5	335.6	(900.9)
Хүлээн авалтын зардал	1,138.2		(1,138.2)
Зар сурталчилгааны зардал	750.0	1,085.8	335.8
Хураамж зөвшөөрлийн зардал	359.6	6,072.8	5,713.2
Газрын төлбөр хураамж	3,943.4	2,745.4	(1,198.0)
Бусад зардал	102,822.2	7,352.5	(95,469.7)
Үйл ажиллагааны зардлын дүн	538,039.6	406,964.8	131,074.8
Борлуулалтын өртгийн дүн	18,170.9	-	18,170.9
Нийт зардлын дүн	556,210.5	406,964.8	149,245.7

Тайлант хугацааны нийт зардал нь өмнөх онтой харьцуулахад 26.83%-иар буурсан үзүүлэлттэй байна.

ТОДРУУЛГА 17. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СЭЖИГТЭЙ БОЛОН МӨНГӨН ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэтцаасны зах зээлийн тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тухайн компанийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай дотоод журам, Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай дотоод журамд заасны дагуу Санхүүгийн нмэдээллийн албанд сэжигтэй гүйлгээний талаар, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзсэн эсхүл 20.0 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээнүүдийг бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн маягты ндагуу бэлтгэн тогтмол мэдээлж байх үүрэгтэй.

ТОДРУУЛГА 18. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

НББОУС 24 Холбоотой талын тодруулгын дагуу холбоотой талууд гэдэг нь нэг тал нөгөө талдаа тодорхой нөлөө үзүүлэх эсвэл санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад нь нөлөөлдөг байхыг хэлнэ.

ТОДРУУЛГА 19. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус компани нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөртэй холбоотой ажил гүйлгээ гараагүй байна.

ТОДРУУЛГА 20. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайлангийн өдөр болон аудитын тайлан бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлтийн талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

ТОДРУУЛГА 21. ТАЙЛАНГИЙН ОРЧУУЛГА

Санхүүгийн тайлангууд нь монгол хэлнээ үйлдэгдсэн бөгөөд монгол хэлнээс өөр хэл дээр орчуулагдсан тохиолдолд орчуулгын ямар нэгэн алдаа гарвал монгол хэл дээрх хувилбарыг баримтлана.

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИ

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан

УДИРДЛАГАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг доор тэмдэглэв.

Асуудал 1. Зардлын данснй талаар

Бодит байдал

1. Тухайн байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд Хувь хүмүүсээс авах авлага дансанд захирал Сайдаброр Рустамходжаевын нэр дээр кассаас бэлнээр баримтгүй гаргасан 2,019,390.5 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Зөвлөмж

1. Цаашид анхан шатны бүрдэл болсон баримтаар зарлагын гүйлгээ хийж, санхүүгийн төлбөр тооцооны журмыг баримталж ажиллах шаардлагатай байна.

Асуудал 2. Компанийн өөрийн хөрөнгийн талаар

Бодит байдал

1. Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээн хувьний лүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан байна.

Зөвлөмж

1. Иймд тухайн байгууллага нь Компанийн тухай хуулийн 31.3-д ‘Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээн хувьний лүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй болгүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувьний лүүлсэн хөрөнгө дөрчлөл торуулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүлтатанбуулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй’ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

“СҮЛД-АУДИТ” ХХК

ЗАХИРАЛ, ПАРТНЕР

Ч. ГҮНДБАЯР

АУДИТОР

Г. ТӨРСАЙХАН

ТАНИЛЦСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САЙДА БРОР РУСТАМХОДЖАЕВ

ЕРӨНХИЙ НЯ-БО

Д.БАТСАЙХАН